

**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2022 оны сарын өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 62 дугаар зүйлийн 62.2, 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д дараах агуулга бүхий хэсэг нэмсүгэй.

1/ Журмын 7.26 дахь хэсэг:

“7.26. Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангах зорилгоор бусдад хувьцаагаа худалдах, шилжүүлэх шаардлагатай банкны нийт гаргасан энгийн хувьцааны 20 хувиас дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж буй этгээдүүдийн хувьцаанд энэ журмын 7.23 дахь хэсэг хамаарахгүй.”

2. Энэ тогтоолын 1-д заасан журамд нэмэлт оруулсантай холбогдуулан өөрийн байгууллагын дүрэм, журамд зохих өөрчлөлтийг оруулж, 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороогоор батламжлуулахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН